



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 03

№ 01/57 ДУА-2018/1СТА-ТШЗ Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээ, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Боловсрол, соёл, урлагийн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайландауд аудит хийх явцад нийт 2,143,800.00 /хоёр сая нэг зуун дөчин гурван мянга найман зуул төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нийт 1,743,800.00 төгрөгийн бэлэн мөнгөний зарцуулалтын тайлан гаргаагүй, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгээн.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.7-д /анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/, Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 тоот тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.7 /мөнгөн кассын санхүүгийн баримт нь засваргүй, үнэн зөв хөтөлгөдөж, баримтын бүрдлийг хангасан байх ба зарлагын толбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэгдэн цохолт хийгдсэн байна/-д заасныг;

2. Орон тооны бус арга зүйч ажиллуулж төсвөөс 400,000.00 төгрөгийн урамшуулалт олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.3 /батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажилчдын цалин хөлсийг тогтоох/, 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн толбор, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн толборийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох

бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хотлоо^{гүй}/, 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зорчсон/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:


1. Дээрх зөрчлүүдийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх, цаашид холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга Ц.Бумангэрэл, нягтлан бодогч Л.Мягмарсүрэн нарт хариуцуулав.


АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР  Б.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА  Ц.БУМАНГЭРЭЛ
НЯГТЛАН БОДОГЧ  Л.МЯГМАРСҮРЭН



¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/